БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Гэр бүл, хүүхэд залуучуудын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БӨА-2023/14/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Өлгий хот<br>2023 он | Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган<br>Утас: 70422954 Цахим хаяг: huanganm@audit.gov.mn<br>Аудитын менежер: Х.Женисбек<br>Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn<br>“Анализ старт Аудит” ХХК-ны захирал: Н.Энхтуяа<br>Утас: 99075818 Цахим хаяг: asaudit.mn@gmail.com<br>Аудитор: Н.Энхтуяа<br>Утас: 99075818 Цахим хаяг:asaudit.mn@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ..... 2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ..... 4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ..... 10
4. АУДИТЫН ТАЙЛАН ..... 13
4.1 Ерөнхий зүйл ..... 13
4.2 Материаллаг байдал ..... 14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ..... 14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ..... 14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 15
4.5.1 Завсрын аудитын талаар .....
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..... 15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ..... 15
5.1 Төлбөрийн акт ..... 15
5.2 Албан шаардлага ..... 15
5.3 Зөвлөмж ..... 15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын стандарт |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

АЙМГИЙН ГЭР БҮЛ, ХҮҮХЭД
ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ЗАХИРАЛ
Х.БАУЫРЖАН ТАНАА

2023.02.17 № 80
танай __________ -ны № __________ -т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлантай холбоотой онцлох асуудал гараагүй.

**Аудитын гол асуудал**

Материаллаг буруу эрсдлийн үнэлгээ өндөр, анхаарах татах асуудал гараагүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.ХУАНГАН

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

**Төгрөгөөр**

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,332,000.00** | **5,121,700.00** |
| 35 | **БАРАА МАТЕРИАЛ** | 1,332,000.00 | 5,121,700.00 |
| 354 | **Хангамжийн материал** | 1,332,000.00 | 5,121,700.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 1,332,000.00 | 5,121,700.00 |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **201,347,117.57** | **2,080,071,414.29** |
| 39 | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 201,347,117.57 | 2,080,071,414.29 |
| 392 | **Биет хөрөнгө** | 161,125,117.59 | 2,040,109,414.35 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 93,995,210.00 | 93,995,210.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (3,916,467.00) | (5,483,053.80) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 42,000,000.00 | 42,000,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (28,683,333.42) | (33,383,333.46) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 94,085,753.00 | 98,722,853.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (46,264,321.14) | (82,249,092.06) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 23,265,084.00 | 31,794,084.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (14,116,257.85) | (16,046,703.33) |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | | 1,910,000,000.00 |
| 39217 | Ном | 759,450.00 | 759,450.00 |
| 393 | **Биет бус хөрөнгө** | 40,221,999.98 | 39,961,999.94 |
| 39301 | Програм хангамж | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (130,000.02) | (390,000.06) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 39,352,000.00 | 39,352,000.00 |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **202,679,117.57** | **2,085,193,114.29** |
| 5 | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **202,642,180.57** | **2,085,193,114.29** |
| 51 | **Засгийн газрын хувь оролцоо** | 202,642,180.57 | 2,085,193,114.29 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 86,957,159.00 | 86,957,159.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 86,957,159.00 | 86,957,159.00 |
| 512 | **Хуримтлагдсан үр дүн** | (142,682,307.43) | 1,739,868,626.29 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (142,682,307.43) | (142,682,307.43) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 1,882,550,933.72 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 258,367,329.00 | 258,367,329.00 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **202,679,117.57** | **2,085,193,114.29** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

**Төгрөгөөр**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **303,233,700.00** | **2,428,984,838.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **-** | **1,794,375.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | - | 1,794,375.00 |
| **120004** | Төсөв байгууллагын өөрийн орлого | - | 1,794,375.00 |
| **1200045** | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | - | 1,794,375.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **303,233,700.00** | **2,427,190,463.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 265,397,300.00 | 2,316,220,600.00 |
| **131001** | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | | 393,054,500.00 |
| **131005** | Хөрөнгийн санхүүжилт | 36,860,400.00 | 1,923,166,100.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 21,500,000.00 | 110,969,863.00 |
| **131103** | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 36,651,500.00 |
| **131104** | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 21,500,000.00 | 74,318,363.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **277,983,525.20** | **546,433,904.28** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **277,983,525.20** | **546,433,904.28** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 277,248,599.20 | 500,285,759.28 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 121,897,402.00 | 175,944,707.00 |
| **210101** | Үндсэн цалин | 80,758,253.00 | 138,414,007.00 |
| **210102** | Нэмэгдэл | 19,920,730.00 | 34,335,400.00 |
| **210103** | Унаа хоолны хөнгөлөлт | | 3,195,300.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 16,320,340.00 | 23,470,163.00 |
| **210201** | Тэтгэврийн даатгал | 11,305,850.00 | 15,889,563.00 |
| **210202** | Тэтгэмжийн даатгал | 1,256,774.00 | 1,895,200.00 |
| **210203** | ҮОМШӨ-ний даатгал | 917,077.00 | 1,516,100.00 |
| **210204** | Ажилгүйдлийн даатгал | 335,491.00 | 379,000.00 |
| **210205** | Эрүүл мэндийн даатгал | 2,505,148.00 | 3,790,300.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 15,145,000.00 | 12,996,500.00 |
| **210301** | Гэрэл, цахилгаан | 440,000.00 | 386,800.00 |
| **210302** | Түлш, халаалт | 14,408,600.00 | 12,288,300.00 |
| **210303** | Цэвэр, бохир ус | 296,400.00 | 321,400.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 17,004,330.00 | 6,403,500.00 |
| **210401** | Бичиг хэрэг | 13,011,150.00 | 2,502,600.00 |
| **210402** | Тээвэр, шатахуун | 3,541,800.00 | 2,980,200.00 |
| **210403** | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 451,380.00 | 802,700.00 |
| **210405** | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 118,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,191,400.00 | 245,000.00 |
| **210604** | Урсгал засвар | 1,191,400.00 | 245,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,495,000.00 | 518,000.00 |
| **210702** | Дотоод албан томилолт | 1,495,000.00 | 518,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 76,702,208.28 | 138,809,916.00 |
| **210801** | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 75,816,825.00 | 137,579,316.00 |
| **210802** | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 180,000.00 |
| **210803** | Даатгалын үйлчилгээ | | 108,900.00 |
| **210804** | Тээврийн хэрэгслийн татвар | 75,344.00 | 84,000.00 |
| **210805** | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 55,000.00 | 55,000.00 |
| **210806** | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 754,020.00 | 802,700.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 27,492,918.92 | 141,897,973.28 |
| **210901** | Бараа үйлчилгээний бусад зардал | 15,571,550.00 | 96,973,370.00 |
| **210902** | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 251,200.00 | 482,800.00 |
| **210903** | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 11,670,168.92 | 44,441,803.28 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 734,926.00 | 46,148,145.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 15,455,600.00 |
| **213207** | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 15,455,600.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 734,926.00 | 30,692,545.00 |
| **213503** | Төвлөрүүлэх шилжүүлэг | 734,926.00 | 30,692,545.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **25,250,174.80** | **1,882,550,933.72** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **25,250,174.80** | **1,882,550,933.72** |

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

**Төгрөгөөр**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **266,373,300.00** | **504,024,363.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **266,373,300.00** | **504,024,363.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 228,536,900.00 | 393,054,500.00 |
| **131001** | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | | 393,054,500.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 21,500,000.00 | 110,969,863.00 |
| **131103** | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 36,651,500.00 |
| **131104** | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 21,500,000.00 | 74,318,363.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **266,276,419.28** | **504,024,363.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **266,276,419.28** | **504,024,363.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **265,541,493.28** | **457,876,218.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 124,544,000.00 | 175,944,707.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **210101** | Үндсэн цалин | 73,658,700.00 | 138,414,007.00 |
| **210102** | Нэмэгдэл | 28,238,000.00 | 34,335,400.00 |
| **210103** | Унаа хоолны хөнгөлөлт | | 3,195,300.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 13,636,800.00 | 23,507,100.00 |
| **210201** | Тэтгэврийн даатгал | 5,294,400.00 | 15,926,500.00 |
| **210202** | Тэтгэмжийн даатгал | 2,085,600.00 | 1,895,200.00 |
| **210203** | ҮОМШӨ-ний даатгал | 1,668,500.00 | 1,516,100.00 |
| **210204** | Ажилгүйдлийн даатгал | 417,100.00 | 379,000.00 |
| **210205** | Эрүүл мэндийн даатгал | 4,171,200.00 | 3,790,300.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 15,145,000.00 | 12,996,500.00 |
| **210301** | Гэрэл, цахилгаан | 440,000.00 | 386,800.00 |
| **210302** | Түлш, халаалт | 14,408,600.00 | 12,288,300.00 |
| **210303** | Цэвэр, бохир ус | 296,400.00 | 321,400.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 3,551,380.00 | 2,182,900.00 |
| **210401** | Бичиг хэрэг | 2,500,000.00 | 852,900.00 |
| **210402** | Тээвэр, шатахуун | 600,000.00 | 409,300.00 |
| **210403** | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 451,380.00 | 802,700.00 |
| **210405** | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 118,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,191,400.00 | 245,000.00 |
| **210604** | Урсгал засвар | 1,191,400.00 | 245,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,495,000.00 | 518,000.00 |
| **210702** | Дотоод албан томилолт | 1,495,000.00 | 518,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 84,294,613.28 | 130,839,648.00 |
| **210801** | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 83,409,230.00 | 129,609,048.00 |
| **210802** | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 180,000.00 |
| **210803** | Даатгалын үйлчилгээ | | 108,900.00 |
| **210804** | Тээврийн хэрэгслийн татвар | 75,344.00 | 84,000.00 |
| **210805** | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 55,000.00 | 55,000.00 |
| **210806** | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 754,020.00 | 802,700.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 21,683,300.00 | 111,642,363.00 |
| **210901** | Бараа үйлчилгээний бусад зардал | 21,402,100.00 | 110,969,863.00 |
| **210902** | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 281,200.00 | 672,500.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **734,926.00** | **46,148,145.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 15,455,600.00 |
| **213207** | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | | 15,455,600.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 734,926.00 | 30,692,545.00 |
| **213503** | Төвлөрүүлэх шилжүүлэг | 734,926.00 | 30,692,545.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

**Төгрөгөөр**

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **C08** | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **86,957,159.00** | **258,367,329.00** | **-142,682,307.43** | 202,642,180.57 |
| **D01** | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **86,957,159.00** | **258,367,329.00** | **-142,682,307.43** | 202,642,180.57 |
| **D02** | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | 0.00 |
| **D03** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **86,957,159.00** | **258,367,329.00** | **-142,682,307.44** | 202,642,180.56 |
| **D08** | Тайлант үеийн үр дүн | | | 1,882,550,933.72 | 1,882,550,933.72 |
| **D09** | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **86,957,159.00** | **258,367,329.00** | **1,739,868,626.28** | **2,085,193,114.28** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**Төгрөгөөр**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 393,054,500.00 | 362,361,955.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 393,054,500.00 | 362,361,955.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 377,598,900.00 | 346,906,355.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 188,671,000.00 | 175,944,707.00 |
| **210101** | Үндсэн цалин | 151,140,300.00 | 138,414,007.00 |
| **210102** | Нэмэгдэл | 34,335,400.00 | 34,335,400.00 |
| **210103** | Унаа хоолны хөнгөлөлт | 3,195,300.00 | 3,195,300.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 23,507,100.00 | 23,507,100.00 |
| **210201** | Тэтгэврийн даатгал | 15,926,500.00 | 15,926,500.00 |
| **210202** | Тэтгэмжийн даатгал | 1,895,200.00 | 1,895,200.00 |
| **210203** | ҮОМШӨ-ний даатгал | 1,516,100.00 | 1,516,100.00 |
| **210204** | Ажилгүйдлийн даатгал | 379,000.00 | 379,000.00 |
| **210205** | Эрүүл мэндийн даатгал | 3,790,300.00 | 3,790,300.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 12,996,500.00 | 12,996,500.00 |
| **210301** | Гэрэл, цахилгаан | 386,800.00 | 386,800.00 |
| **210302** | Түлш, халаалт | 12,288,300.00 | 12,288,300.00 |
| **210303** | Цэвэр, бохир ус | 321,400.00 | 321,400.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 2,469,500.00 | 2,182,900.00 |
| **210401** | Бичиг хэрэг | 852,900.00 | 852,900.00 |
| **210402** | Тээвэр, шатахуун | 409,300.00 | 409,300.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **210403** | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 802,700.00 | 802,700.00 |
| **210405** | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 404,600.00 | 118,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 245,000.00 | 245,000.00 |
| **210604** | Урсгал засвар | 245,000.00 | 245,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 521,800.00 | 518,000.00 |
| **210702** | Дотоод албан томилолт | 521,800.00 | 518,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 148,515,500.00 | 130,839,648.00 |
| **210801** | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 147,262,200.00 | 129,609,048.00 |
| **210802** | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 180,000.00 | 180,000.00 |
| **210803** | Даатгалын үйлчилгээ | 126,100.00 | 108,900.00 |
| **210804** | Тээврийн хэрэгслийн татвар | 84,000.00 | 84,000.00 |
| **210805** | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 60,500.00 | 55,000.00 |
| **210806** | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 802,700.00 | 802,700.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 672,500.00 | 672,500.00 |
| **210902** | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 672,500.00 | 672,500.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 15,455,600.00 | 15,455,600.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 15,455,600.00 | 15,455,600.00 |
| **213207** | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 15,455,600.00 | 15,455,600.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 393,054,500.00 | 362,361,955.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 393,054,500.00 | 362,361,955.00 |
| **131001** | Улсын төсвөөс санхүүжих | 393,054,500.00 | 362,361,955.00 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1.00 | 1.00 |
| **610001** | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 15.00 | 19.00 |
| **620001** | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 |
| **620002** | Гүйцэтгэх ажилтан | 14.00 | 11.00 |
| **620003** | Үйлчлэх ажилтан | - | 7.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **15.00** | **19.00** |
| **650001** | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 15.00 | 12.00 |
| **650009** | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | | 7.00 |

### 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **110,969,863.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **110,969,863.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 110,969,863.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 110,969,863.00 |
| **210901** | Бараа үйлчилгээний бусад зардал | 110,969,863.00 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

***Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар***

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар нь Гэр бүлийн тулгуур үнэт зүйлд суурилсан хүүхэд, залуучуудын хөгжил, оролцоог нэмэгдүүлэх, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх, эрхийг хангах, хамгааллыг бэхжүүлэх цогц бодлогыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий байгууллага. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газарт санхүүгийн тайлангаа нэгтгэлд тушаадаг байгууллага юм.

Тус газар нь 2022 онд байгууллага нь нийгмийн дараах 3  салбарт чиглэн эдгээр зорилтуудыг хэрэгжүүлэн ажилласан байна.

Дээрх зорилгыг биелүүлэхээр дараах зорилтыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Гэр бүлийн үнэт зүйлсийг бэхжүүлж, хүчирхийллийг бууруулах, хүчирхийлэлд өртөгчдийг хамгаалах, гэр бүлийн хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлийн үйл ажиллагааг зохион байгуулах.
- Хүүхдийн эрх хамгааллын чиглэлээрх төрийн бодлого, шийдвэр, хууль тогтоомж, төсөл, үндэсний хөтөлбөр, олон улсын гэрээ конвенцийн хэрэгжилтийг хангах, сурталчлах, нийгмийн бүх орчинд хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хамгаалах үйл ажиллагааг зохион  байгуулах.
- Залуучуудын хөгжил, оролцоог хангах талаарх төрийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, залуучуудын хөгжил, оролцоог дэмжсэн нийгмийн үйлчилгээ үзүүлэхэд салбар дундын зохицуулалтыг хангах, залуучуудад чиглэсэн хөтөлбөр, төсөл, үйл ажиллагааг холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

***Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар***

Гэр бүл, хүүхэд залуучуудын газар нь Гэр бүлийн тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Жендерийн эрх тэгш байдлын тухай хууль,Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль болон бусад байгууллагуудад мөрдөж байгаа хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

Улсын Их Хурлаас Төсвийн тухай хуульд 2022 оноос хуулиар оруулсан өөрчлөлтөөр нийгмийн салбарын байгууллагууд улсын төсвөөс санхүүжиж, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийг газарт санхүүгийн тайлангаа нэгтгэлд тушаадаг болсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тухайлбал: Байгууллагаас гарч байгаа тушаал шийдвэр болон байгууллагын даргын тушаал шийдвэрийн хэрэгжилт, хуулийн үндэслэл бусад байгууллага, иргэдээс ирүүлсэн албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн байдал, байгууллагын дотоод ажлын зохион байгуулалт хөдөлмөрийн сахилга, ажлын цаг ашиглалт, байгууллагын ажлын төлөвлөгөөний биелэлт, дээд байгууллагын тогтоол шийдвэрийн биелэлт, байгууллагын удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт зэрэг ажил хамрагдаж байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь тус аймгийн төсөвт байгууллагуудын санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм. Гэр бүл, хүүхэд залуучуудын газар 2022 онд шалгалтад хамрагдаагүй тул дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Гэр бүл, хүүхэд залуучуудын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

***Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар***

Гэр бүл, хүүхэд залуучуудын газрын захирлын 2021 оны 01 дугаар сарын 05-ны өдрийн А/02 тоот тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ашигладаг байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Гэр бүл, хүүхэд залуучуудын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 53.0 сая төгрөгөөр буюу 2.53 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | - | - | - |
| Бараа материал | 1332.0 | 5.121.7 | 3.789.7 |
| Үндсэн хөрөнгө | 201.347.1 | 2.080.071.4 | 1.878.724.3 |
| Нийт хөрөнгө | 202.679.1 | 2.085.193.1 | 1.882.514.0 |

| | | | |
|---|---|---|---|
| Өр төлбөр | 36.9 | - | -36.9 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 202.642.2 | 2.085.193.1 | 1.882.550.9 |
| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн | **202.679.1** | **2.085.193.1** | **1.882.514.0** |

Бараа материал, үндсэн хөрөнгө дансанд өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Авлагын данс өөрчлөлтгүй байна.

Үндсэн хөрөнгийн данс 1.878.7 сая төгрөгөөр өссөн нь 1.923.1 сая төгрөгийн хөрөнгийг нэмж орлого авч, үндсэн хөрөнгөнд тайлант онд 44.4 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй гэсний дагуу тус сургууль нь 2022-2023 оны төсвийн хүрээний мэдэгдлийг зохих журмын дагуу боловсруулан дээд шатны удирдлагад өгч батлуулсан байна.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 355.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийг хянаж Төсвийн төслийн саналаас зардлыг 37.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж 393.1 сая төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийн хуваарьт өөрчлөлт оруулсан байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 13 арга хэмжээг санхүүжүүлэхээр 393.1 сая төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 393.1 сая төгрөгийн санхүүжилт авч 30.7 сая төгрөгийн төсөв төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 362.4 сая төгрөг буюу 92.2 хувьтай байгаа нь үндсэн цалингийн зардлын төсвийг 12.7 сая төгрөгөөр, хангамжийн материалын зардлын төсвийг 0.9 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийн зардлыг 17.7 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/ мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| **1** | Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал | 188,671,000.00 | 175,944,707.00 | 12,726,293.00 | 91,6% |
| **2** | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 23,507,100.00 | 23,507,100.00 | | 100.00% |
| **3** | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 12,996,500.00 | 12,996,500.00 | | 100.00% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **4** | Хангамж, бараа материалын зардал | 2,469,500.00 | 2,182,900.00 | 286,600.00 | 88.40% |
| **5** | Эд хогшил худалдан авах | 245,000.00 | 245,000.00 | | 100.00% |
| **6** | Томилолт, зочны зардал | 521,800.00 | 518,000.00 | 3,800.00 | 99.30% |
| **7** | Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний зардлын зориулалт | 1,253,300.00 | 1,230,600.00 | 22,700.00 | 90.20% |
| **8** | Бараа үйлчилгээний бусад нийтлэг зардлын зориулалт | 672,500.00 | 672,500.00 | | 100.00% |
| **9** | Шүүхийн шийдвэрийн дагуу олгох | 6,339,400.00 | 2,980,950.00 | 3,358,450.00 | 0.00% |
| **10** | Ажил олгогчоос олгох тэтгэмж, | 15,455,600.00 | 15,455,600.00 | | 100.00% |
| **11** | Эрсдэлийн болон НБҮ хийх | 11,200,000.00 | 6,000,373.00 | 5,199,627.00 | 46.20% |
| **12** | Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний зардал | 51,200,000.00 | 42,104,925.00 | 9,095,075.00 | |
| **13** | Урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардал | 51,300,000.00 | 51,300,000.00 | | 100.00% |
| **14** | Залуучууд болон оюутнууд | 19,100,000.00 | 19,100,000.00 | | 100.00% |
| **15** | Гэр бүлийн хөгжил, хамгаалал | 8,122,800.00 | 8,122,800.00 | | 100.00% |
| | **Дүн** | **393,054,500.00** | **362,361,955.00** | **30,692,545.00** | 92.19% |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Гэр бүл, хүүхэд залуучуудын газар 2022 онд 111.0 сая төгрөгийн нэмэлт төсөв авч зориулалтын дагуу зарцуулсан байна.

### *3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн*

Гэр бүл, хүүхэд залуучуудын газар 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Гэр бүл, хүүхэд залуучуудын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн

байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Улаанбаатар хотын “Анализ старт аудит” ХХК-ны аудитор Н.Энхтуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Гэр бүл, хүүхэд залуучуудын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 35 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 278,0 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 4.2 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад алдаа, зөрчил илрээгүй.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд Шилэн дансны мэдээллээс шалгах программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгав. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 100.0% байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Гэр бүл, хүүхэд залуучуудын газарт завсрын аудит хийгдээгүй байна. Өмнөх оны аудитаар 12.3 сая төгрөгийн 1 албан шаардлага өгөгдсөнийг хэрэгжүүлсэн байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/ төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | | | | | |
| Албан шаардлага | 1 | 12.350.3 | 1 | 12.350.3 | 100% |
| Зөвлөмж | | | | | 100% |
| **Нийт дүн** | **1** | **12.350.3** | **1** | **12.350.3** | **100%** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн зарцуулалтыг түүвэрлэн шалгасан тул гүйцэтгэлийн аудитаар дэлгэрэнгүй шалгах шаардлагатай байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд 30.7 сая төгрөгийн залруулга хийгдсэн.

Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн эх үүсвэрт Улсын төсвийн санхүүжилтээс төвлөрүүлэг шилжүүлгийг цэвэрлээгүй тайлагнасныг улсын төсвийн санхүүжилтээс цэвэрлэж залруулсан.

Аудитаар алдаа зөрчил илрээгүй болно.

### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй.

### 5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй.

### 5.3 Зөвлөмж

Зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс Залруулсан | | Үүнээс Залруулаагүй | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Төсвийн гүйцэтгэлийн тайлангийн эх үүсвэрээс төвлөрүүлэг | 1 | 30.692.5 | | | 1 | 30.692.5 | 1 | 30.692.5 | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| шилжүүлгийг цэвэрлээгүй | | | | | | | | | | | | |
| **Дүн** | **1** | **30.692.5** | | | **1** | **30.692.5** | **1** | **30.692.5** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Нийт дүн | | | | | | | | |